



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/101

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, мөн зүйлийн 6.4, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйл, 27 дугаар зүйлийн 27.1, мөн зүйлийн 27.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мера” ХХК-ийн үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг 3 /гурван/ жилийн хугацаагаар сунгасугай.

2. “Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх” тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг хавсралт ёсоор хүчингүй болгосугай.

3. “Мера” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавих болон тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон аж ахуйн нэгж, байгууллагуудад болон холбогдох төрийн байгууллагуудад мэдэгдэл хүргүүлж, мэдээллийг мэдээллийн санд бүртгэхийг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Даваадорж/-т даалгасугай.

САЙД



Ц.ДАШДОРЖ

08 0260

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2017 оны 05 дүгээр сарын 17-ний өдрийн
А/101 дугаар тушаалын хавсралт



Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан аж ахуйн нэгжүүд

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага	Тусгай зөвшөөрлийн төрөл	Хугацаа дууссан огноо
1	"Баянтэгш импекс" ХХК /3389А, 6454А, 12203А тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд/	Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил хийх	2014.09.27
2	"Дунфанлунма" ХХК /11855А тусгай зөвшөөрөлтэй талбайд/		2015.03.27
3	"Бэрэн майнинг" ХХК		2017.01.28
4	"Гоби коул энд энерги" ХХК		
5	"Баян эрч" ХХК		
6	"Цагаан ташаа" ХХК		2017.04.21
7	"Аравжих мандал" ХХК /MV-015590 тусгай зөвшөөрөлтэй талбайд/		2014.12.15
8	"ММНС" ХХК	Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх	2016.11.21
9	"Аранжинболд" ХХК		2017.01.28
10	"Санваллей" ХХК	Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэрх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах	2015.05.09
11	"Эм Би Икс Би" ХХК	Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэрх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх	2016.11.21